

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

*1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар
2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/* 3-4

*2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих
журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 4-7

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
05 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Сүхбаатар, Д.Ганбат, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 14 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Байнгын хорооны нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 17-ны өдрийн ХЗБХ-ны хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.2-т Байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол түүнийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ гэж заасан байна.

Байнгын хорооны ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Адьшаа гишүүн ирсэн байна, Бат-Амгалан гишүүн ирсэн байна, Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Нямбаатар гишүүн ирсэн байна, Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Раднаасэд гишүүн ирсэн байна, Сандагдорж гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Цогтбаатар гишүүн ирсэн байна. Мөнх-Оргил гишүүн томилолттой, Мөнхцэцэг гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Б.Энх-Амгалан гишүүн ҮХЦ-ийн хуралдаанд оролцож байгаа чөлөөтэй, Сэргэлэн гишүүн чөлөөтэй. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Энд хамт яачихсан байна шүү. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах

өөрчлөлтийн төсөл Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудал. 2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Нинжбатын Ууганбаатар МУИС-ийн Шинжлэх ухаан сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор. Хүрэлбаатарын Баасанжаргал Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө холбогдох хуулийн заалтуудыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ гаргана. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж ТББХ-нд өгнө гэж тус тус заасан байна.

Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Журмын тухай хуульд зааснаар үг байхгүй. Санал гишүүдээс гаргасан санал байхгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал хураалт явуулъя. Санал хураалтын томъёоллыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа. дараагийн асуудалд оръё.

11.19 цаг

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Раднаасэд гишүүнээр тасаллаа Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Би түрүүн болгоомж юу анхааралгүй байж байгаа түрүүний юман дээр нэг, энэ одоо зүгээр л юунд үлдэх ёстой протоколд. Их Хурал өөрөө өөрийнхөө бүрэн эрхийг нэмэгдүүлсэн өөрчлөлтийг нэмэлтийг Үндсэн хуульд Их Хурал өөрөө санаачилж болохгүй. Ерөнхийлөгч мөн ижилхэн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлсэн, ЗГ бас ижилхэн. Тийм учраас энэ 176-г 152 болгоно гэж ЗГ-аас оруулж ирж байгаа. Тэгээд энэ одоо санал гаргах эрх, санаачлах эрх гэж 2 тусдаа байх ёстой. Санаачлах эрх бол зөвхөн Их Хурлын бүрэн эрхийг нэмэгдүүлэх асуудал дээр Их Хурал хэзээ ч оролцох ёсгүй.

Тийм ч учраас бид нар анхны одоо дэмжих эсэх санал хураалт дээр зөвшөөрнө, татгалзана гэж санал өгч байгаа. Одоо ингээд 152-ыг ихэсгэх, багасгах зарчмын зөрүүтэй санал гаргах эрх Их Хурлын гишүүдэд бий юү? Өнөөдрийн хуулиар бол болно ч гэсэн юм байхгүй, болохгүй ч гэсэн юм байхгүй. Энэ өөрөө Үндсэн хуулийн практикт аягүй маш том асуудал байхгүй юу. Одоо 152-ыг дараа нь 512 болгоод хэн нэгэн оруулахыг ч үгүйсгэхгүй. Болохгүй гэж орсныг нь Их Хурал дээр орж ирээд болно гэж өөрчилж бас болно. Тэгээд тийм эрх Их Хурлын гишүүдэд өнөөдөр байгаа юү? Их Хурал яг институтийнхээ хувьд ЗГ-аас санаачилсан Үндсэн хуулийн өөрчлөлт дээр Их Хуралтай хамаарал бүхий аливаа асуудал дээр Их Хурлын гишүүд санал гаргаж өөрчлөлт оруулах эрхтэй юү?

Зүгээр том зургаараа бол манай зарим хуульчид бол оруулах ёстой л гэх байх. Дотоод, гадаад аливаа асуудал дээр хэлэлцэн шийдвэрлэнэ гэж байгаа юм чинь. Зүгээр онолын хувьд энэ ийм байх ёстой юу, үгүй юү? Одоо энэ бусад

улсуудад ямар байдаг юм бэ? Энэ бол бидний хувьд бол анхны тохиолдол болж байна шүү дээ. Урьд өмнө нь хэзээ ч ийм тохиолдол гарч байгаагүй. Мэдээж цаашдын хожмын өдрүүдэд бас ийм юм гарах л байх л даа. Тэгээд энийг зүгээр танин мэдэхийн хувьд бид нар нэг ойлголтой болох ёстой. Цааш цаашдаа энэ хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой практикт аягүй маш сайн нэгдсэн нэг ойлголтыг бий болгож, энэ хожмын өдөр энэ судлаачид болоод, энэ хууль боловсруулагчдад өөрсдөд нь том юу болох ёстой л доо. Бас нэг том практикийн нэг том асуудал болж үлдэх нь л дээ. Энэ дээр яг тэгж судалсан юмнууд байна уу, үгүй юү?

Б.Энхбаяр: Нямбаатар сайдад хариулъя.

Х.Нямбаатар: Яах вэ 22 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 01, 02 гэсэн дүгнэлт гаргасан байгаа. Ингэхдээ ҮХЦ Монгол Улсын Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг анх удаагаа ашигласан. Өөрөөр хэлбэл 68.2-т Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хууль санаачлах эрх бүхий субъектээр одоо дамжуулж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм процесс байж болно гэж анх 1992 оны Үндсэн хуулийг одоо батлахдаа ийм агуулгаар 68.2-ыг бичигдсэн гэж ойлгож байгаа юм.

Ингээд 68.2-ын агуулгаар хууль санаачлах эрх бүхий субъект буюу Улсын Их Хуралд Цэцийн дүгнэлтийг танилцуулсан саналтай нь цуг өөрөөр хэлбэл энэ дотор 1 дүгээрт Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, олон улсад хэрэглэгдэж байгаа сонгуулийн дэвшилтэт одоо тэр зарчим аргуудыг нэвтрүүл гэсэн ийм агуулгатай саналыг ирүүлсэн. Энэний дагуу 22 онд Монгол Улсын Их Хурлын 34, 54 дүгээр тогтоолууд гарч, 54 дүгээр тогтоолоор Монгол Улсын ЗГ-т уг Үндсэн хуулиас ҮХЦ-ээс ирүүлсэн саналаар хуулийн төсөл боловсруулах

ийм үүргийг Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолоор үүрэгжүүлсэн. Үүний дагуу Монгол Улсын ЗГ Монгол Улсын Үндсэн хуулийн 21.2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүдийн тоо, сонгууль явуулах тэр тогтолцооны агуулгыг хөндсөн ийм заалт бүхий өнөөгийн өөрчлөлтийг өргөн бариад байгаа.

Раднаасэд гишүүний асууж байгаа болгоомжилж байгаа зүйл бол мянга, 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай тухай хуулиар Их Хурал өөрийнхөө эрх хэмжээг нэмэгдүүлсэн өөрчлөлтийг өргөн барихгүй, ЗГ өөрийнхөө эрх хэмжээг өргөн баригдуулсан нэмэгдүүлсэн. Мөн энд Раднаасэд гишүүн би андуураагүй бол эрх хэмжээг нэмэгдүүлэх болон бууруулсан гэж байгаа юм. Аль, аль тохиолдолд 3 субъект өөртэй нь холбоотой, эрх хэмжээтэй холбоотой ийм асуудлаар хуулийн төсөл өргөн барихгүй гэж байгаа юм. Энэ агуулгаараа бол ҮХЦ-ийн 68.2-ыг үндэслээд ЗГ-ын өнөөдрийн тогтоолын төсөл хуулийн төсөл маань 2010 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуультай харшилдахааргүй байдлаар явж байгаа гэж нэг талаасаа ойлгож болно.

2 дугаарт таны асууж байгаа зүйл бол нэгэнт Их Хурал өөрийнхөө эрх хэмжээг нэмэгдүүлэхгүй заалттай юм чинь хууль санаачлах эрх, санал гаргах эрх хоёрын хооронд хэр их зарчмын зөрүү байгаа вэ гэвэл онолын хувьд Монгол Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж санал гаргах, түүнийгээ санал хураалтад оруулах энэ эрх нь хадгалагдаж байгаа юм. Хууль санаачлах эрх бүхий субъект нь нөгөө талдаа ЗГ-т хадгалагдаж байгаа бол түүнийг хэлэлцэн батлах тэр эрх хэмжээ бол өнөөдөр хууль тогтоох тэр эрхийг эдэлж байгаа парламентад хадгалагдаж байгаа. Түүний нэгж эд эс болсон гишүүн

нь уг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал гаргах, түүнтэйгээ холбоотой санал хураалгах эрх нь нээлттэй байгаа.

3 дахь үндэслэл гэвэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар мөн ялгаагүй Их Хуралтай холбоотой Их Хурал өөр бусад одоо бусад субъектүүдээс Их Хуралтай холбоотой, эрх хэмжээтэй холбоотой асуудлаар өргөн барьсан төсөл дээр Их Хурлаар хэлэлцүүлэх явцад Их Хурлын гишүүд Их Хуралтай холбоотой заалт дээр санал гаргах эрхгүй гэсэн хориглосон болон хязгаарласан заалт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд бас байхгүй зохицуулалтгүй байгаа. Ингэхээр нөгөө талдаа Их Хурлын тухай хууль, Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль цаашилаад Үндсэн хуульд заасан Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар санал гаргаж хураалгах тэр эрх хадгалагдана гэж бид ойлгож энэ төсөл.../минут дуусав/

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Бямбацогт, Учрал нар хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүдээс гараад бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Адьшаа гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Энэ сая одоо энэ ажлын хэсгийн гишүүн Нямбаатар сайд бас энэ нэг ҮХЦ-ийн л одоо өгсөн чиглэлээр л ийм хуульд өөрчлөлт оруулах тухай ийм л асуудал болоод байгаа мэтээр энэ Доржханд, Тогтохсүрэн

нарын хэлээд байгаа юмыг давтаад байна. Энэ ҮХЦ гэдэг байгууллага бол өнөөдөр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар иргэд гомдол гаргасан нөхцөлд, Дээд шүүх зэрэг эрх бүхий төрийн байгууллагаас гаргасан гомдлын дагуу л асуудал шийддэг ийм одоо хуультай шүү дээ. Тэгээд л өнөөдөр ингээд л нэг ҮХЦ Их Хурлын гишүүдийг тоог нэмэх чиглэл өгсөн мэтээр, Үндсэн хуульд ийм зүйл оруулах мэтээр ингэж өнөөдөр ингээд яриад байвал энэ юм чинь юм чинь ямар байдлаар ойлгогдох юм бэ?

Энэ ҮХЦ гэдэг энэ байгууллагыг энэ сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд аливаа муу муухай зүйлийг гүйцэтгүүлдэг ийм байгууллага болсон гэдэг энэ иргэдийн одоо энэ хардалттай энэ чинь бараг санал зөвшөөрөөд байгаа юм биш үү. ҮХЦ өнөөдөр Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэлд халдах тийм эрх байхгүй. Та бүхэн бас энэ дээр бас их дүгнэлттэй байгаарай, бодолтой байгаарай. Монгол Улсын ҮХЦ гэдэг энэ байгууллага бол төрийн эрх мэдэл, түүнчлэн хууль тогтоох эрх мэдлийн аливаа асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчмын хүрээнд хяналт тавьдаг шүүх эрх мэдэл байна шүү дээ. Энэ ҮХЦ яахаараа өнөөдөр хууль тогтоох эрх мэдлийн талаар одоо чиглэл өгөх бараг тийм улс төрийн шийдвэр гаргадаг ийм байдалтай мэтээр ингэж тайлбарлаж болохгүй байна.

Тэгэхлээр энэ ҮХЦ-ийн одоо өгсөн ийм дүгнэлтээр, ийм санаагаар гээд л өнөөдөр ингээд л энэ улс төрийн намуудын том, том дарга нар ийм юм яриад байгаа юм. Би энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг ер нь дэмжиж хэлэлцье, бас ард иргэдтэйгээ бас энэ тогтолцооны өөрчлөлтийг, энэ тогтолцооны гажуудлыг, энэ 30 жилийн өнөөдөр энэ гацсан төрийн энэ зүйлийг бас засаж залруулъя. Иргэд олон түмэн саналыг бодъё ийм бодолтой байдаг юм. Гэтэл өнөөдөр энэ Монгол Улсын ҮХЦ-ийг энэ хууль тогтоох эрх мэдлийн бүрэн эрхэд халдсан чиглэл өгсөн мэтээр ингэж ярьж

энэ хуулийнхаа юунд оруулсан энэ асуудал дээр бас нэг хариулт нэмж авъя гэж бодож байна.

Яагаад гэхээр өнөөдөр энэ ҮХЦ гэдэг энэ шүүх эрх мэдлийн өгч байгаа чиглэл тайлбар мэтээр тийм санааг оруулсан мэтээр ингэж байх юм бол энэ хууль тогтоох эрх мэдэл чинь бид нар энд байж яах юм. Цэцээрээ шийдвэр гаргаад л, тэгээд л тэр нь ингээд явна биз. Энэ дээр нэг тайлбар авъя. Одоо энэ ажлын хэсгээс.

Б.Энхбаяр: Үндсэн хууль, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад бол оролцогчоос асуулт асууж болно гэсэн байна. Тэгэхээр Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд Адышаа гишүүний хөндсөн асуудлаар бол алга байна. Тэгэхээр хариулт өгөх ийм боломж дэгээрээ алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал 3 дугаар зүйл дээр алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг ТББХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтад Бямбацогт дарга унших уу та? Байнгын хороо Төрийн

байгуулалт дээр. Бямбацогт дарга танилцуулна.

11.33 цаг

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА